



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

**ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА СУРГАЛТЫН
ХҮРЭЭЛЭН**

**ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ
БИЙ БОЛГОХ**

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА



МОНГОЛБАНК
МОНГОЛ УДСЫН ТӨВ БАНК

Бүлэг 1

Ерөнхий тойм

- + Асуудал
- + Шийдэл

Бүлэг 2

Санхүүгийн
хүртээмж

- + Зээлий
хүүний тааз
ба санхүүгийн
хүртээмж
- + Хөгжиж буй
орнуудад
- + Хөгжингүй
орнуудад

Бүлэг 3

ЕХ-ны эрхзүйн
орчин

- + Мөнгө
хүүлэлтийн
тухай хууль
тогтоомжийн
тойм

Бүлэг 4

Хариуцлагатай
зээлийн үзэл
баримтлал

- + Мөнгө хүүлэлт
бий болох
шалтгаан
болон
гаргалгаа
- + Хариуцлагатай
зээлийн
зарчим

Бүлэг 5

Дүгнэлт

- + Санал
- + Дүгнэлт

Ерөнхий тойм

Санхүүгийн хүртээмж

ЕХ-ны эрхзүйн орчин

Хариуцлагатай зээл

Үзүүлэлт	Огт санал нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Зарим тохиолдолд санал нийлнэ	Санал нийлж байна	Бүгдэд нь санал нийлж байна	Нийт
Зээлдүүлэгч тал зээлийн гэрээг чандлан баримталдаг	11,4	21,1	42,0	19,6	6,0	100
Зээл авагчийн эрхийн хуулиар олгогдсон хамгаалалт сайн	14,6	26,4	43,0	13,9	2,1	100
Зээлийн мэдээллийн сан (зээлийн эх үүсвэрүүд, хэмжээ, зээл авах боломж гэх мэт) хангалттай	15,0	25,4	42,3	14,7	2,6	100
Санхүүжилтийн орчин үеийн хэлбэрүүд (angel investor, venture) сайн хөгжсөн	17,6	30,3	40,9	9,5	1,7	100
Батлан даалтаар санхүүжилт авах боломж сайн	23,5	30,5	34,9	9,9	1,2	100

Эх сурвалж: Бизнесийн орчны судалгаа

Санхүүгийн зах зээлийн орчинд үнэлгээний үзүүлэлтүүд (дээд утга 7)

1. Банк санхүүгийн үйлчилгээний төрөл – 3,32 (-3,68 буюу 7-оос ийм оноогоор дутуу байна)
2. Хувь нийлүүлэгчдийн эрх – 2,91 (-4,09)
3. Зээл авахад хялбар байдал – 2,81 (-4,19)
4. Хөрөнгийн зах зээлд оролцох боломж – 2,69 (-4,31)
5. Дотогш чиглэсэн хөрөнгө оруулалт – 2,55 (-4,45)
6. Хөрөнгө оруулалтыг урамшуулах бодлого – 2,38 (-4,62)
7. Зээлийн хүүгийн хувь хэмжээ – 2,31 (-4,69)
8. Мөнгөний ханшийн хэлбэлзлийн бизнес дэх нөлөөлөл – 2,24 (-4,76)

Эх сурвалж: Бизнесийн орчны судалгаа

Ерөнхий тойм

1-р үе буюу 1993-1997 онд хүүгийн зөрүү маш өндөр буюу 19,8%-иас (1993) 163,5% (1994 он)-ийн хооронд хэлбэлзэж байсан бөгөөд гиперинфляц хамгийн өндөр байсан (183%) 1993 онд зээлийн хүү 300%, депозитийн хүү 280,2, хүүний зөрүү 19,8% байв.

2-р үе буюу 1998-2003 онд инфляц 1,7-10%-д хэлбэлзэж байсан орчинд хүүгийн зөрүү эрс буурч тогтвортой түвшинд үндсэндээ хадгалагдаж 14,8-23,1% түвшинд хэлбэлзэж байв. Гэхдээ инфляц 1,7%; хамгийн дор түвшинд байсан 2002 онд хүүгийн зөрүү 22,3% байсан буюу өндөр түвшинд хадгалагдаж байсан нь банкуудын хувьд инфляцийн төрөл, хэлбэр болон банкуудын инфляцийн хүлээлтийн тооцооноос илүү ашгийг максимум хэмжээнд хүргэх авир төрх нь давамгайлж байсныг харуулж байна. Энэ хугацаанд Төв банкны зүгээс мөнгөний агрегатуудыг онилох зорилт хэрэгжиж байсан ч банкны зах зээл дээр давамгайлж байсан авир төрх энэ бодлогын нөлөөнд бага орж байсныг мөн харуулж байна.

3-р үе буюу 2004-2009 онд Монголбанкны зүгээс мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг зах зээлд шинээр нэвтрүүлэх, инфляцийг онилох бодлогын бэлтгэл ажлыг хийх, 2005-2006 оноос де-факто инфляцийг онилох эхний үе шатыг эхлүүлсэн орчинд хэдийгээр хугацааны тал хэсэгт инфляц 2 оронтой тоонд байсан ч хүүгийн зөрүү ялангуяа 2006 оноос буурч нэг оронтой тоонд орж 2009 онд 8,4% болсон байв.

4-р үе буюу 2010-2016 онд инфляц хугацааны ихэнхэд 2 оронтой тоонд орж инфляцийг онилсон зорилтууд хэрэгжиж чадаагүй, (ханшийн нөлөөлөл, нийлүүлэлтийн гаралтай инфляц болон эргэлтээр өдөөгдсөн инфляцийн дарамт өндөр байсан гэх мэт), **эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр түвшингээс буурч ирсэн, 2015-2016 онд эдийн засгийн орчлын бууралтын мөчлөгт орсон, дисинфляц үргэлжилсэн, дефляцийн шинж тэмдэг зарим улиралд илэрсэн орчинд банкуудын ч хүүний зөрүү буурч 2011-2016 онд 6,1-6,7% түвшинд хэлбэлзэж 2017 оны байдлаар 6,97% буюу бага зэрэг нэмэгдсэн байна.**

Санхүүгийн хүртээмж

ЕХ-ны эрхзүйн орчин

Хариуцлагатай зээл

	хүүгийн зөрүү%	депозитийн хүү%	зээлийн хүү %	Инфляци
1993	19.8	280.2	300.0	183.0
1994	163.5	115.7	279.2	66.3
1995	59.8	74.6	134.4	53.1
1996	43.2	44.8	87.9	44.6
1997	45.7	36.4	82.1	20.5
1998	14.8	33.3	48.1	6.0
1999	20.6	23.4	44.0	10.0
2000	20.2	16.8	37.0	8.1
2001	23.1	14.3	37.4	8.0
2002	22.3	13.2	35.5	1.7
2003	17.9	14.0	31.9	4.7
2004	17.3	14.2	31.5	11.0
2005	17.6	13.0	30.6	9.5
2006	13.9	13.0	26.9	6.2
2007	8.4	13.5	21.8	17.8
2008	9.2	11.4	20.6	22.1
2009	8.4	13.3	21.7	4.2
2010	8.2	11.9	20.1	13.0
2011	6.1	10.5	16.6	8.9
2012	6.8	11.3	18.1	14.0
2013	6.4	12.0	18.5	12.5
2014	6.7	12.3	19.0	11.0
2015	6.6	13.0	19.6	1.9
2016	6.5	13.3	19.7	1.2

Эх сурвалж: Монголбанк

Ерөнхий тойм

Санхүүгийн хүртээмж

ЕХ-ны эрхзүйн орчин

Хариуцлагатай зээл

		Бодлогын хүү	Банкны хөрөнгө ба ДНБ-ий харьцаа	Банкны капитал ба хөрөнгийн харьцаа	Банкны чанаргүй зээлийн хувь	Зээл, депозитийн хүүний зөрүү	Онилсон инфляц	Зээлийн хүү ба Засгийн газрын үнэт цаасны хүүний зөрүү	Инфляц	Нөөцийн шаардлага
			2014	2016	2016	2016	2017	2016	2016	
1	Albania	1.25	65.33			8.8	3.00±1	8.6	1.3	10
2	Angola	18.00		8.4	10.6	10.2		0.6	34.7	21
3	Argentina	28.75±1.50	21.16	11.2	1.8	7	12-17			20.0
4	Armenia	6.00	50.79	16.2	6.7	5.7	4.00±1.50	7.5	-1.3	2.0
5	Azerbaijan	15.00 (+5.50)	29.60			8.6		3.4	4.2	0.50
6	Barbados	3.00				7.7		4.7		
7	Belgium		78.27	6.8	3.8	9.1		10.1	2.0	
8	Bhutan		46.62	17.6	6.6	10.2			4.4	
9	Bolivia		41.71	7.3	1.6	6.5		7.7	3.6	
10	Botswana	5.00	32.67	8.4	4.9	5.2	3.00-6.00		3.8	
11	Brazil	7.00	100.32	9.3	3.9	39.7	4.50±1.50	38.6	8.7	
12	Bulgaria	0.00	71.97	11.6	13.2	6.2		7.1	-0.8	
13	Cabo Verde		83.31			7		9	-1.4	15.0
14	Central African Republic			19.2	25.6					0.00
15	Chile	2.50	78.5	8.4	1.8	1.8	3±1		3.8	
16	China	4.35	143.39	8.4	1.7	2.9	3.00		2.0	17.0
17	Colombia	4.75	48.57	16.2	3.1	7.9			7.5	
18	Congo, Dem. Rep.	6.00				15.6				2.0
19	Costa Rica		57.83	9.4	1.6	10.4	3.0±1		0.0	15.0
20	Croatia		99.27	14	13.6	5.4	2.0±1		-1.1	12.0
21	Czech Republic	0.50	66.81	7.6	4.6	3.5	4.0±1		0.6	2.0
22	Dominican Republic	5.25	27.94	9.1	1.7	7.9			1.6	
23	El Salvador		112.19	13.5	2.1				0.6	
24	Gambia, The		39.32	14.8	6.5	12			7.2	15.0
25	Georgia	7.25	44.97	13.2	3.4	2.7	5.00	4.2	2.1	7.0
26	Ghana	20.0	26.6	13.2	17.3		8.00±2		17.5	10.0
27	Greece		131.32	10.7	36.3	6.8		7.7	-0.8	
28	Honduras		60.29	10.4	2.9	10.7	4.00±1		2.7	
29	Hungary	0.90	60.02		7.4	1.9		1.4	0.4	1.0
30	India	6.00	68.44	7.2	9.2		4.00±2		4.9	4.0

Ерөнхий тойм

Банкны системийн эдийн засагт эзэлж буй байр суурь Төв банкны мөнгөний бодлогод нөлөөтэй, түүний дотор Төв банкнаас хэрэгжүүлдэг мөнгөний бодлогын уламжлалт болон уламжлалт бус аргуудад өөр өөр нөлөө үзүүлдэг байж болохоор байна.

Санхүүгийн хүртээмж

Банкны системийн эдийн засагт эзэлж буй хувь хэмжээ эдийн засагт эзэлж буй хувь хэмжээ 50%-иас дээш тодорхой түвшин, 50%-иас доош тодорхой түвшин хүртэл инфляцийн зорилтот түвшин болон хүүгийн зөрүүнд өөр өөр байдлаар нөлөөлж болох юм.

ЕХ-ны эрхзүйн орчин

Ихэнх хөгжилтэй улсын хувьд 100% даваад ирэх үед инфляцийг нам дор түвшинд байлгах зорилго тавих, бодит инфляц нь зорилтот түвшингийнхээ дотор, бүр доошоо орж дефляц болдог, нөөцийн шаардлага хэрэгцээгүй болж Төв банкуудын нь инфляцийг онилох зорилго нь уламжлал ёсоор байдаг ч гол нь эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг онилох, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх гэх мэт макро зорилго чухал болдог.

Зүгширч буй (emerging) эдийн засаг бүхий зарим улсын хувьд энэ харьцаа 100% рүү дөхөх, давж гарах нөхцөлд хэдийгээр инфляцийн нам дор түвшинг хангаж чадаж буй ч хүүгийн зөрүү өндөр байх нөхцлүүд байсаар байгаа нь инфляц онилох, бодлого, нөөцийн шаардлагыг хэр зэрэг уян хатан ашиглахаас үр дүн нь хамаарч байна.

Хариуцлагатай зээл

Санхүүгийн
хүртээмж

1

Монгол улс бол энэ талын ямар ч зохицуулалтгүй буюу тодруулан хэлбэл их төлөв **ганц талын ашиг сонирхлыг илэрхийлсэн** зохицуулалттай бөгөөд энэ нь банкны болон банк бус байгууллагуудын тухай хууль тогтоомжид тусгагдсан байдаг.

2

“бичил зээлийн нэрээр бий болсон **шинэ мөнгө хүүлэгчид**” (“new loan sharks created in the name of microcredit”)

3

Ялангуяа орлого багатай өрхүүдэд нийгмийн бусад давхаргатай харьцуулахад бичил зээлийн нөхцөлүүд хүнд тусдаг тул “poor pay more syndrome” буюу “**ядуус илүү ихийг төлөх синдром**” гэсэн хэллэг судалгааны үр дүнд гарсан байдаг.

Хариуцлагатай
зээл

Ерөнхий тойм

Асуудал

Шийдэл

бодлогын чиглэл нь **санхүүгийн үйлчилгээний тухай** сайн боловсруулсан дизайн бүтэц, үр ашигтай зохицуулалтуудын **багц хууль гаргах шаардлагатай** болж байна

Санхүүгийн
хүртээмж

хариуцлагатай зээллэг
(responsible lending)

реклам
сурталчилгааны
хяналт

үнэн зөв, бодитой
мэдээллээр хангах

ЕХ-ны эрхзүйн
орчин

санхүүгийн
хэрэглэгчдийн
хамгаалалт

мөнгө хүүлэлтийн
эсрэг зохицуулалтууд

зээлийн гэрээний
эрх тэгш байдал

шударгын
зарчим

үйлчилгээний төлбөрийн хэмжээ


Хариуцлагатай
зээл

зээлийн эргэн төлөлтийг хэрэглэгчдэд
дарамтгүй байдлаар, хүчирхийлсэн
бус байдлаар хэрэгжүүлэх

Ерөнхий тойм

Иймэрхүү графиктай төстэй үйл явц практик дээр нилээн олон улсад тохиолдож байсныг судалгаануудад харуулсан ба зах зээл дээр тогтсон тэнцвэрийн хүүг шууд эвдэн “хүссэн түвшинд” хязгаарлалт хийснээр олон сөрөг үр нөлөө гарч болохыг баталж байна.

Санхүүгийн хүртээмж



Никарагуа
Баруун Африк
Колумб
Кени
Япон

ЕХ-ны эрхзүйн орчин

- 1) **зах зээлийн хумигдал (market contraction)**
- 2) **үнэ бүрдэлтийн ил тод байдал алдагдах** гэсэн 2 зүйл тохиолдож байна.

Хариуцлагатай зээл

Ерөнхий тойм

Хөгжиж буй орнуудад зээлийн хүүний тааз тогтоосон байдал

Санхүүгийн хүртээмж

ЕХ-ны эрхзүйн орчин

Хариуцлагатай зээл

Улс орон, бүлгүүд	Хязгаарлалтууд
Хойд Африк (Морокко, Тунис, Ливи, Алжир, Египет)	Сард 3-5% байх
Баруун Африкийн нэгдлийн орнууд	Бичил зээлийн хязгаар нь 27%
Бангладеш	27%-ийн бодит түвшин
БНХАУ	БНХАУ-ын Ардын банкны бодлогын хүүнээс (reference rate) 4 дахин илүү байхаас хэтэрч болохгүй
Энэтхэг	Өмнө нь 26% +1LPF одоо 12% маржины дээд хязгаар +1% LPF
Мьянмар	Сард 2,5%
Болив, Бразил, Чили, Колумб, Гватемал, Эквадор, Никарагуа, Перу, Уругвай, Венесуэл	Өмнөх жилүүдэд зээлийн хүүний хяналт тогтоож байсан, одоо үндсэндээ байхгүй.

Ерөнхий тойм

Бичил санхүүжилтийн зээлийн хүүний хязгаарлалтын хэлбэр

Санхүүгийн хүртээмж

ЕХ-ны эрхзүйн орчин

Хариуцлагатай зээл

Зээлийн хяналт	хүүний Мөнгө хуулалтийн хязгаар	De-facto хяналт
Алжир	Армен	Бразил
Бахама	Боливи	БНХАУ
БНХАУ	Бразил	Этопи
Ел Салвадор	Чили	Лаос
Энэтхэг	Колумб	Непал
Киргиз	Эквадор	Пакистан
Ливи	Гватемал	Шриланк
Морокко	Гондурас	Тайланд
Мьянмар	Киргиз	Вьетнам
Филиппин	Никарагуа	
Парагвай	Флиппин	
Сири	Өмнөд Африк	
Турк	Уругвай	
Тунис	Венесуэл	

Европын холбооны зээлийн хүүний хязгаарлалтууд

Ерөнхий тойм

Санхүүгийн
хүртээмж

ЕХ-ны эрхзүйн
орчин

Хариуцлагатай
зээл

Улс	Хамрах хүрээ	Хязгаарлалт
Туйлын хязгаарлалттай		
Грек	Зөвхөн банкны бус зээл	6,75%
Ирланд	Хувийн зээл олгогчид (moneylenders)	Жилийн нэрлэсэн хүүний дагуу хэмжээг (APR) тогтоодог, зээлийн холбоодын хувьд 12,68%
Мальта	Чөлөөлөлт ихтэй	8%
Харьцангуй хязгаарлалттай		
Бельги	Бүх зээлдүүлэгчид	10%-19,5%, 12 ангилалтай
Эстон	Бүх зээлдүүлэгчид	Жилийн дундаж зарласан хүүнээс (APR) 3 дахин их байх дээд хязгаар, сар бүр тогтоодог.
Франц	Бүх зээлдүүлэгчид	Дараагийн хүснэгтэнд байгаа
Герман	Бүх зээлдүүлэгчид	Дараагийн хүснэгтэнд байгаа
Итали	Бүх зээлдүүлэгчид	Мах. APR =150% дундаж, APR мах 27,2%
Нидерланд	Моргейж орохгүй 200 еврогоос дээш бүх зээлдүүлэгчид	Мах= APR 12%+ хууль ёсны APR (5%, 6 сар тутамд тогтоодог)
Польш	Бүх зээлдүүлэгчид	20%, Төв банкны хүүгээс 4 дахин ихээс хэтрэхгүй.
Португал	Бүх зээлдүүлэгчид	133% дундаж APR, 31,6% хүртэл
Словак		Дундаж APR-аас 2 дахин ихээс хэтрэхгүй, 30 төрөлтэй
Словени	Зөвхөн банк бус зээл	Дундаж APR-аас 2 дахин ихээс хэтрэхгүй, зээлийн нөхцөл, хугацаанаас хамаардаг.
Испани	Овердрафт зээл, нийтийн орон сууцны зээл	10%, албан ёсны хүүгийн түвшнээс 2,5 дахин ихээс хэтрэхгүй.

Ерөнхий тойм

Хэрэглээний зээлийн хүүний хязгаарлалт

Санхүүгийн
хүртээмж

Улс	Хязгаарлалтын статус
Франц	Францын Төв банкнаас тогтоосон дундаж түвшингээс 33% дээш хэмжээний таазтай. 3 төрлийн зээлэнд.
Герман	Хуулинд заасан тааз байхгүй ч дундаж хүүнээс 2 дахин илүү таазыг (2006 онд тах 21,1%) шүүх тогтоож болно. APR-ийн зайлшгүй хураамжийг зааж өгсөн байдаг.
Япон	Бүх хураамжийг оруулаад 20%-ийн дээд түвшинтэй. Нэг зээлдэгчийн хувьд 500 мянган иенээс дээш олон зээлдэгчийн хувьд 1 саяаас их иений зээл гаргасан бол зээл авагчдын санхүүгийнхээ арга хэрэгслүүдийг баталгаажуулах шаардлагатай ба бүх зээлийн хувьд зээл авагчийн жилийн орлогын гуравны нэгээс хэтэрч болохгүй.
Их Британи	Тааз тогтоодоггүй. Гэрээ шударга, ил тод байх, хариуцлагатай зээллэгийн зарчимуудыг хэрэгжүүлэх
АНУ	6 муж зээлийн хүүний таазгүй цалингийн зээлийг (payday loans) зөвшөөрдөг. 31 муж 14 хоногийн хугацаатай дээд хязгаарт тогтоож цалингийн зээлийг зөвшөөрдөг. 12 мужид цалингийн зээлийг зөвшөөрдөггүй. 2 мужид ломбардны (pawn broking эсвэл pawnshop гэж нэрлэдэг) дээд хязгаарыг тогтоохгүйгээр үйл ажиллагааг нь зөвшөөрдөг.

ЕХ-ны эрхзүйн
орчин

Хариуцлагатай
зээл



Дүгнэлт, зөвлөмж

Санхүүгийн хүртээмж

1

“Санхүүгийн хэрэглэгч” гэсэн нэр томъёог хэрэглэгчийн эрхийн тухай болон төв банк, банкны тухай хууль, банк бус санхүүгийн байгууллагууд, санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд тусган оруулж санхүүгийн хэрэглэгчийн эрх, үүргийн талаарх эрх зүйн орчныг бий болгох

2

“Мөнгө хүүлэлт” гэсэн нэр томъёоны хууль зүйн тодорхойлолтыг олон улсын туршлагын дагуу гаргах, мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн орчныг иргэний хууль, банкны болон банк бус санхүүгийн байгууллагын тухай, хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуульд холбогдох нэмэлтийг оруулах

3

СЗХ-оос ББСБ-уудын зээлийн хүүний судалгааг иж бүрэн хийдэг болох, тэдгээрийг зээлийн хүүний түвшин болон бусад нөхцөлүүдээ олон нийтэд ил тод зарлах журам, түүнчлэн зээлийн зар сурталчилгааг хийхдээ хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулахгүй байх, өөрсдийн хэрэглэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар тодорхой үйл ажиллагаа, сургалт явуулах

Ерөнхий тойм

Санхүүгийн хүртээмж

ЕХ-ны эрхзүйн орчин

Хариуцлагатай зээл

Улсын нэр	нэршил	"мөлжлөг" (exploitation)	Тааз (ceiling)	Бусад
Австри	Wucher	Иргэний ба эрүүгийн хуулийн тусгай заалтууд	Иргэний заалт	Хэрэглээний зээлийн зохицуулалтын хуулиар тааз тогтоосон иргэний хуулиар хүүнээс хүү бодохыг зохицуулсан
Бельги	Wocker/ Usure	Эрүүгийн хуулийн тусгай заалт		
Болгар	Нихварство	Гэрээ, үүргийн хуулиар зохицуулсан		
Чех	Lichval/ dobre mravy	Иргэний ба эрүүгийн хуулиар	"Дунджаас 4 дахин дээгүүр" (шүүхийн дүрэм)	
Эстон	Lijgkas/ urotmine	"сайн ёс суртахуун" (иргэний хуульд)		
Финлянд	Kiskominen	Эрүүгийн хууль	Хэрэглэгчийн тухай хууль, Иргэний хууль: "сайн ёс суртахуун", дунджийг 2 дахин нэмсэн байдлаар	
Франц	Usure			
Герман	Wucher	Иргэний хууль, эрүүгийн хууль		
Грек	Mokoy	Эрүүгийн хууль	Шүүгч зээлийн хүүг бууруулж болно.	
Унгар	Uzsozakamat	Гийм		
Ирланд	Excessive	"Excessive" хэрэглээний зээлийн хууль		
Итали	Usura	Эрүүгийн хууль		
Латви	Anglosana	Эрүүгийн хууль "эрх чөлөөнөөс салах"		
Люксембург	Usure	Иргэний ба эрүүгийн хууль		
Мальт	Usury	Хууль бус. Гэхдээ мэргэжлийн байгууллагуудад зориулсан чөлөөлөлт ихтэй		
Нидерланд	Woekeraar	Эрх зүйн томъёолол байхгүй. Гэхдээ мөнгө хүүлэлтийг эрүүгийн гэмт хэрэгт тооцдог.	Зээлийн хууль ёсны хүү "тогтоосон" байдаг.	
Польш	Lichva	Бүх гүйлгээнд мөнгө хүүлэлтийг хориглодог.		
Португали	Usura	Иргэний ба эрүүгийн хууль	Иргэний хууль, банкны хууль	
Румын	Camaturie	Эрүүгийн хууль		Итгэмжлэгдээгүй зээл 1 жилээс бага хугацаатай
Словак	Usura	Эрүүгийн хууль	>30% ра (хууль зүйн яамны тушаал)	
Словени	Oderustvo	Үүргийн тухай хууль, Эрүүгийн хууль		
Испани	Usura	Мөнгө хүүлэлтийн тухай хууль (1908 оны)	Хэрэглээний зээлийн хууль	
Швед	Ockret	Гэрээний хууль (1915 оны)	Эрүүгийн хууль	
Их Британи	Usury/ unfair	Өндөр буюу хэт өндөр хүүтэй зээлдүүлэх (хуулиар тогтоогоогүй)	Зээлийн холбоод зохицуулдаг.	



Дүгнэлт, зөвлөмж

Санхүүгийн хүртээмж

1

“exploitation” (мөлжлөг) гэсэн ойлголт талаас аваад үзвэл Европын ихэнх улсад Иргэний болон Эрүүгийн хууль тогтоомждоо “usury” гэсэн тодорхойлолтыг оруулж өгсөн байна. Тухайлбал, Германы Иргэний хууль энэ утгаар их түгээмэл бөгөөд уг хуульд “usury” мөнгө хүүлэлт гэдгийг: хэт өндөр (excessive) ашиг хийх зорилгоор тухайн этгээдийн эсвэл тухайн байдлын сул талыг санаатайгаар ашиглах (exploitation) гэж тодорхойлсон байна. Иймэрхүү загварууд Германаас гадна Австри, Бельгийн улсууд Скандинавийн улсууд, Грек, Нидерланд, Словак улсад байна.

2

Зээлийн өндөр хүү гэсэн зээлийн хязгаарлалтын хоёр дахь хэлбэрийн хувьд Португали, Франц, Бельги, Испани улсаас гадна Словени, Чех, Словак, Унгар, Ирланд, Англи, Германы “case law” гэж нэрлэдэг хуулиудад байна. “Мөлжлөг, ашиглах” гэсэн утгатай зээлийн хүүний хязгаарлалтын хэлбэрийн оронд хэрэглэгдэж буй мөнгө хүүлэлтийн энэ хэлбэрийг Иргэний хуульдаа голцуу тодорхойлсон байдаг ба зах зээлийн дундаж түвшний зээлийн хүүгээс илүү тогтоосон зээлийн хүүнд хамааралтай байхаар зохицуулжээ.

Ерөнхий тойм

гэнэтийн, хүлээж,
төлөвлөж байгаагүй
үйл явдлууд

Санхүүгийн
хүртээмж

“financial imprudence” буюу
санхүүгийн боломжгүй байдал

харилцагчийнхаа боломж нөхцөлийн үнэлгээ
(affordability assessment) хийгээгүй байх

ЕХ-ны эрхзүйн
орчин

predatory lending

ядуурал

Чөтгөрийн тойрог

Хариуцлагатай
зээл

зээлдэгчдийг хэт өрөнд оруулах
(overindebtness)

Хариуцлагатай зээл





Дүгнэлт, зөвлөмж

1

Дэлхийд одоогоор 76 улс ямар нэг хэлбэрээр зээлийн хүүний хязгаарлалт хийж байгаа бөгөөд 28 улс usury law буюу мөнгө хүүлэлтийн эсрэг хуультай, 24 улс зээлийн хүүний хууль, 9 улс холбогдох төрийн байгууллагад (Төв банк, шүүх, парламент, сангийн яам) де-факто хязгаарлалт (тааз) хийх эрх олгосон байна.


2

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалсан хууль эрх зүйн орчин дутмаг улсад энэ чиглэлийн орчноо бүрдүүлэхгүйгээр дээд хязгаарыг шууд болон шууд бус хэлбэрээр тогтоох нь тэр бүр хүссэн үр дүнд хүрдэггүй бөгөөд энэ бол Монгол улсын хувьд онцгой анхаарах ёстой асуудал юм.

3

Монгол улсын Иргэний хуульд зээлийн гэрээтэй холбоотой асуудлаар шүүхийн эрх мэдлийн одоо байгаа хүрээг өргөтгөх, мөнгө хүүлэлтийн тухай тодорхойлолт оруулж өгөх, шүүх энэ чиглэлээр ямар шийдвэр гаргаж болохыг Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдэж болох юм





Дүгнэлт, зөвлөмж

Санхүүгийн
хүртээмж

Дэлхийн банк тиймээс доорх чиглэлүүдээр бодлогын зөвлөмж өгдөг бөгөөд эдгээр нь:

1. Өрсөлдөөн
2. Санхүүгийн хэрэглэгчийн хамгаалалт
3. Санхүүгийн хэрэглэгчийн боловсрол
4. Зээлийн мэдээлэл
5. Бичил зээлийн бүтээгдэхүүн
6. Зээлийн хүүний хязгаарлалт буюу тааз тогтоох

ЕХ-ны эрхзүйн
орчин

Эдгээр чиглэлээс харахад Монгол улсын хувьд эхний 5 чиглэлээр хангалттай хэмжээнд бодлогын арга хэмжээ, эрх зүйн орчин бүрэлдүүлээгүй мөртлөө шууд 6-р чиглэл буюу сөрөг үр нөлөө нь их байгаа зээлийн хүүний тааз тогтоох, ингэхдээ шууд хуулиар, абсолют байдлаар тоо заах хуулийн төсөл яригдаж байгаа нь арга зүйн хувьд төдийгүй бодлогын хандлага талаасаа зохистой бус, иж бүрэн бус байгаа нь тодорхой байна.

Хариуцлагатай
зээл





АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА